



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2025 оны 02 сарын 26 өдөр

Дугаар A/81

Улаанбаатар хот

**Арилжаанд оролцох эрх олгох тухай**

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3.1, 3 дугаар зүйлийн 3.3.3 дахь заалтууд болон "Би ди сек ҮЦК" хувьцаат компанийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 25/105 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гишүүн "Би ди сек ҮЦК" ХК-ийн ажилтан Б.Ононгийн нэр дээр бүртгэлтэй BDSC3.BO, Э.Мэндсайханы нэр дээр бүртгэлтэй BDSC1.EM үнэт цаасны арилжаанд оролцох эрхүүдийг цуцалсугай.
2. "Би ди сек ҮЦК" ХК-ийн компанийн ажилтан Б.Хонгор (РД:НЭ00301637), О.Түвшинсанаа (РД:УХ01281353) нарт Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг шинээр олгосугай.
3. Арилжаанд оролцох эрх авсан ажилтнуудад Монгол Улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
4. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т үүрэг болгосугай.
5. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын алба (Ч.Эрдэнэболор)-нд тус тус даалгасугай.

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**



**Б.ДӨЛГӨӨН**

**1525080186**